



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

᠑᠙᠙3 оны 04 сарын ᠒᠖ өдөр

Дугаар А/᠑᠖3

Мандалговь

Аймгийн хурдан морины бүсийн  
уралдааны 2023 оны хуваарийг  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9<sup>1</sup>.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн “Нарны хүлэг” морин спорт уяачдын холбооны Тэргүүлэгчдийн 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн VI тогтоолыг харгалзан 2023 онд зохион байгуулах аймгийн хурдан морины бүсийн уралдааны хуваарийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Хурдан морины уралдааныг холбогдох хууль тогтоомж болон “Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавигдах шаардлага” MNS6264:2018 стандартыг бүрэн хэрэгжүүлэн, хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангаж, өндөр зохион байгуулалттай явуулахыг сумдын Засаг дарга, аймгийн “Нарны хүлэг” морин спорт уяачдын холбоо (Л.Алтанхуяг)-нд тус тус даалгасугай.

3. Хурдан морины уралдааны явцад байнгын хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Ц.Ганзориг), Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/96 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ

4823100705

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын  
9-ны өдрийн 7-дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ХУРДАН МОРИНЫ БҮСИЙН УРАЛДААНЫ  
2023 ОНЫ ХУВААРИЙГ ШИНЭЧИЛСЭН ХУВААРЬ

№	Уралдааны нэр	Уралдаан зохион байгуулагдах газар	Уралдах нас	Хугацаа
1	"Мандлын хурд-2023" аймгийн төвийн бүсийн хурдан морины уралдаан	Сайнцагаан сум	а/ Их нас б/ Соёолон в/ Хязаалан г/ Сонгомол дээд нас	2023.05.01 2023.05.02
2	"Efes Cup 2023" Эфэсийн группын нэрэмжит уралдаан	Сайнцагаан сум	а/ Шүдлэн б/ Даага	2023.05.02
3	"Дэлгэрхангай уулын тахилга" аймгийн баруун бүсийн хурдан морины уралдаан	Дэлгэрхангай сум	а/ Их нас б/ Соёолон	2023.05.29
4	"Хамарцагаан Баянжаргалан уулын тахилга" аймгийн зүүн бүсийн хаврын уралдаан	Баянжаргалан сум	а/ Азарга б/ Их нас в/ Соёолон г/ Сонгомол бага	2023.05.27
5	Дундговь аймгийн зүүн бүсийн хурдан морины уралдаан	Гурвансайхан сум	а/ Соёолон б/ Шүдлэн в/ Даага г/ Сонгомол дунд	2023.07.09